



МОНГОЛ УЛСЫН  
САНГИЙН САЙДЫН ТУШААЛ

2019 оны 01 сарын 31 өдөр

Дугаар 17

Улаанбаатар хот

Төсвийн хуваарьт өөрчлөлт  
оруулах тухай

Монгол Улсын 2019 оны төсвийн тухай хууль болон Төсвийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.13 дахь заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1. Сангийн сайдын 2018 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн 309 дүгээр тушаалын "Монгол Улсын 2019 оны төсвийн орлогын сар, улирлын хуваарь"-ийг 1 дүгээр хавсралтаар, "Монгол Улсын 2019 оны төсвийн зарлага, санхүүжилтийн сар, улирлын хуваарь"-ийг 2 дугаар хавсралтаар, "Монгол Улсын 2019 оны төсвийн хөтөлбөр, арга хэмжээний сар, улирлын хуваарь"-ийг 3 дугаар хавсралтаар, 6 дугаар хавсралтаар батлагдсан "Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас 2019 онд аймаг, нийслэлийн орон нутгийн хөгжлийн санд олгох орлогын шилжүүлгийн сар, улирлын хуваарь"-ийг 4 дүгээр хавсралтаар, 11 дүгээр хавсралтаар батлагдсан "Монгол Улсын 2019 оны төсвийн алдагдлыг санхүүжүүлэх эх үүсвэрийн сар, улирлын хуваарь"-ийг 5 дугаар хавсралтаар тус тус өөрчлөн баталсугай.

2. Санхүүжилтийг төсвийн хуваарийн дагуу олгохыг Төрийн сангийн газар /М.Батхуяг/-т зөвшөөрсүгэй.



Ч.ХҮРЭЛБААТАР







































